



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэх хэсэг 4.2.4 дэх заалтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй “Хүннү эмпайр ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэлх хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1520030262